



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2020 оны 7 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 99

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө батлах тухай

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

3. “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний салбар дундын хэрэгжилтийг хангаж, дүнг танилцуулж ажиллахыг Жендэрийн үндэсний Хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Т.Энхбаяр)-д үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ДУНДАЖ НАСЛАЛТЫН ЗӨРҮГ БАГАСГАХ ТАЛААР
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2020-2022)

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2019	Зорилтот түвшин 2022	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Зорилт 1. Эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах							
1.1.	Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв, техникийн коллеж, Их дээд сургуулийн эрэгтэй оюутнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байх	2020-2022	- Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан эрэгтэй оюутны тоо	0	86,000	- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам; - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам; - Төр, хувийн хэвшлийн боловсролын байгууллага	- Эрүүл мэндийн ерөнхий газар; - Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
1.2.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд “Байгууллагын эрүүл мэндийн үзлэг”-ийг хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах	2021-2022	- Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах тухай заалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байгууллагын тоо; - Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан албан	0	478,000	- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам; - Жендэрийн үндэсний хороо; - Бүх шатны Засаг даргын Тамгын газар, Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага	- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг; - Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага

	Нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинетыг (андрологийн) байгуулах	2020-2022	хаагчдын мэдээлэл - Нэгдсэн эмнэлэгт бий болсон тасаг кабинетын тоо, эмч нарын тоо, үйлчлүүлсэн хүний тоо	4	30	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг
1.3.	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтаар андрологийн төрөлжсөн мэргэшлийн эмч бэлтгэх	2021-2022	- Андрологийн мэргэшил эзэмшсэн эмчийн тоо; - Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмчийн тоо	6	20	Эрүүл мэндийн яам	- Эрүүл мэндийн хөгжлийн төв; - Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
Зорилт 2. Зам, тээврийн шалтгаант ослоос урьдчилан сэргийлэх замаар эрэгтэйчүүдийн осол гэмтэл, нас баралтыг бууруулах							
2.1.	Олон улсын болон улсын чанартай авто зам дагуу камерын хяналтын системээр тээврийн хэрэгслийн хурд, бусад зөрчлийг хянах мэдээллийн нэгдсэн системийн программ хангамж, техник хангамжийн хөгжүүлэлт хийх	2021-2022	- Улсын хэмжээнд ашиглах (LPR) буюу тээврийн хэрэгслийн дугаарыг таньж илрүүлэх камеруудын мэдээллийг нэгтгэн хадгалдаг болсон байх; - 100000 хүн амд ногдох зам, тээврийн ослын шалтгаант нас баралтыг 2 нэгжээр бууруулсан байна	-	-	Цагдаагийн ерөнхий газар	- Хууль зүй, дотоод хэргийн яам; - Зам, тээврийн хөгжлийн яам
2.2.	Жолооны сургалтын болон давтан сургалтын хөтөлбөрт зам, тээврийн ослоос	2021	- Сургалтын гарын авлага боловсруулан, хөтөлбөрт тусгасан жолооны сургалтын	0	100	- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;	- Хууль зүй, дотоод хэргийн яам;

	шалтгаалан гарч буй үр нөлөө, жолоочийн сэтгэл зүй, хариуцлагатай жолооч болох талаарх агуулгыг нэмэх, гарын авлагыг бэлдэх	2020-2022	төвийн тоо	489	20%	-Мэргэжлийн боловсрол сургалтын төв	-Цагдаагийн ерөнхий газар; -Жолооны сургалтын төвүүд
2.3.	Малчин эрэгтэйчүүдийн дунд өргөнөөр хэрэглэж байгаа мотоциклын ослыг бууруулах чиглэлээр болон бага насны хөвгүүдэд мотоцикл жолоодуулахгүй байх талаар үндэсний аян зохион байгуулах	2020-2022	- Мотоциклын ослын эсрэг зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан; - Мотоциклын ослын тоо	489	20% бууруулах	- Цагдаагийн ерөнхий газар; -Тээврийн цагдаагийн алба; -Соёл урлагийн газар	Орон нутгийн бүх шатны Засаг даргын Тамгын газар
2.4.	Интернэт орчинд эрэгтэйчүүдийн сонирхол, нас, амьдарч буй газар оронд тохирсон контентын шинэ хэлбэрийг ашиглан зам, тээврийн осол, аваар, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг түгээх	2021-2022	- Нийгмийн сүлжээний сувгуудаар дамжуулан зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан, үзэлт хандалтын тоо	0	100,000	Цагдаагийн ерөнхий газар	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
2.5.	Соёлтой, хариуцлагатай, зөрчил гаргаагүй жолоочийг сурталчлах, урамшуулах зорилгот	2021-2022	- Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан;	0	50,000	- Цагдаагийн ерөнхий газар;	-Шатахуун худалдааны компаниуд;

	арга хэмжээг эрэгтэй жолооч зориулан зохион байгуулах		- Хамрагдсан жолоочийн тоо		-Тээврийн цагдаагийн алба	-Даатгалын компаниуд
Зорилт 3. Хөвгүүд, эрэгтэйчүүдийн эрүүл зөв аж төрөх мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах замаар чанартай, урт наслалтыг дэмжих						
3.1.	НӨАТ-ын баримт бүртгүүлэх системийг ашиглаж эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдах талаар болон эрүүл аж төрөх амьдралын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх мессеж, мэдээ түгээх	2020-2022	0	500,000	Сангийн Яам	<ul style="list-style-type: none"> - Үндэсний статистикийн хороо; - Жендэрийн үндэсний хороо
3.2.	Уран бүтээлээр дамжуулан эрчүүдэд амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх, хорт зуршлын хэрэглээг бууруулахыг уриалсан тайз, дэлгэцийн бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх	2021-2022	0	1	<ul style="list-style-type: none"> - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам; - Соёл урлагийн газар 	<ul style="list-style-type: none"> - Жендэрийн үндэсний хороо; - Төрийн бус байгууллагууд
3.3.	Эрэгтэйчүүдийн физиологи, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх уриалга, арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах	2020-2022	-	-	<ul style="list-style-type: none"> - Батлан хамгаалах яам; - Эрчим хүчний яам; - Зам, тээврийн хөгжлийн яам; 	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн яам; - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;

								<ul style="list-style-type: none"> -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам; -Биеийн тамир, спортын газар; -Соёл урлагийн газар 	<ul style="list-style-type: none"> -Бүх шатны төрийн болон төрийн бус байгууллагууд
3.4.	<p>Малчин эрэгтэйчүүдэд чиглэсэн амьдралын зөв дадал бий болгох, эрүүл урт наслах зан үйлийг хэвшил болгох зорилгот өрнүүлэх</p>	2020-2022	-Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан		-		<ul style="list-style-type: none"> -Соёл урлагийн газар; -Орон нутгийн бүх шатны Засаг даргын Тамгын газар 	<ul style="list-style-type: none"> -Эрүүл мэндийн яам; -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар; -Аймгуудын хөгжимт драмын театр, чуулга; -Нийслэлийн соёлын төв ордон 	
3.5.	<p>Эрэгтэйчүүдийн сонирхлоороо нэгдэж буй клуб, спортын төрлөөр дамжуулан стресс тайлах, сэтгэл зүйн зөвлөгөөг түгээх, зөв үлгэр дуурайлал үзүүлж буй бүлэг, клубыг дэмжих, сурталчлах</p>	2020-2022	<ul style="list-style-type: none"> - Клуб, спортын холбоотой хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан ; - Клуб, спортын холбоодын тухай нэгдсэн мэдээллийн сан, статистик бий болох - Сургалтад хамрагдсан нийгмийн ажилтнуудын тоо 		0	1	<ul style="list-style-type: none"> -Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн; -Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв; -Биеийн тамир, спортын газар 	<ul style="list-style-type: none"> -Эрүүл мэндийн яам; -Жендэрийн үндэсний хороо; -Спортын клуб, холбоод; -Төрийн бус байгууллагууд -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар; 	
3.6.	<p>Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан (сэтгэл зүйч)-ийг</p>	2020 –2022		0	800		<ul style="list-style-type: none"> -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам; 		

	хүйсийн онцлог хэрэгцээнд нийцсэн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах		- Сургуулиудын сэтгэл зүйн зөвлөгөө авсан хүүхдүүдийн тоо, статистик үзүүлэлтүүд		-Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт	-Сэтгэл зүйн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд
3.7.	0-18 нас хүртэлх хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч нарт чиглэсэн эрэгтэй, эмэгтэй хүүхдийн эрүүл өсөж бойжих эрхийг хангах, талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилтот арга хэмжээ зохион байгуулах, гэр бүлийн боловсрол олгох сургалтын агуулгад тусгах	2020-2022	<ul style="list-style-type: none"> - Эцэг, эх, асран хамгаалагч нарт хандсан уриалга, зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан; - Гэр бүлийн боловсрол олгох сургалтын агуулгад тусгагдсан байдал 		<ul style="list-style-type: none"> -Эрүүл мэндийн яам; -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам; -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар; -Өмчийн хэлбэр харгалзахгүй сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль 	Бүх шатны Засаг даргын Тамгын газар
3.8.	0-12 насны хүүхэдтэй эцэг, өрх толгойлсон эрэгтэйчүүдэд зориулан гэр бүлдээ зарцуулах цагийг уртасгах боломжийг бүрдүүлэх, гарсан сайн туршлагыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх	2020-2022	<ul style="list-style-type: none"> - 0-12 насны хүүхэдтэй эцэг, өрх толгойлсон эрэгтэйчүүдийн ажлын цагт уян хатан бодлого хэрэгжүүлсэн байгууллагын тоо 	0	<ul style="list-style-type: none"> Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 	<ul style="list-style-type: none"> -Төрийн албаны зөвлөл; -Төрийн захиргааны байгууллагууд болон бүх шатны Засаг даргын тамгын газар; -Жендэрийн үндэсний хороо; -Монголын

							<p>Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо;</p> <p>-Аж ахуйн нэгж байгууллага</p> <p>-Төрийн албаны зөвлөл;</p> <p>-Жендэрийн үндэсний хороо;</p> <p>-Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв;</p> <p>-Аж ахуйн нэгж Байгууллага;</p> <p>-Төрийн бус байгууллагууд</p>
3.9.	<p>“Сэтгэцийн эрүүл мэнд-Аюулгүй ажлын байр”, “Стрессгүй ажлын байр” зэрэг аян өрнүүлэх замаар стрессийг даван туулах, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг түгээх сургалт, зөвлөгөө өгөх</p>	2020-2022	<ul style="list-style-type: none"> - Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр зохиох үйл ажиллагааны тайлан 			<p>-Төрийн захиргааны төв байгууллага болон захиргааны байгууллага;</p> <p>-Бүх шатны Засаг даргын Тамгын газар</p>	
3.10	<p>Уул уурхай, дэд бүтцийн салбарт ажилладаг эрэгтэйчүүд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх аян, сургалт зохион байгуулах замаар ялангуяа уул уурхай, барилгын салбарын үйлдвэрлэлийн ослыг бууруулах</p>	2020-2022	<ul style="list-style-type: none"> - Сургалтад хамрагдсан эрэгтэйчүүдийн тоо; - Зохион байгуулсан мэдээлэл түгээх үйл ажиллагаа, аяны тоо; - Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн ослын тоо 	13.8	13.0	<p>Бүх шатны Засаг даргын тамгын газар;</p> <p>-Аж ахуйн нэгж байгууллага;</p> <p>-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;</p> <p>-Барилга, хот байгуулалтын яам;</p> <p>-Зам, тээврийн хөгжлийн яам</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам</p>

Зорилт 4. Үндэсний хэмжээнд хүйсээр ангилсан мэдээллийг өргөтгөн сайжруулах, хөвгүүд, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээг анхаарсан хөгжлийн төлөвлөлтийг эхлүүлэх.									
4.1.	Үндэсний хэмжээнд хүйсээр ангилсан мэдээллийн санг өргөжүүлэх	2020-2022	-Хүйсээр ангилсан өгөгдөл, мэдээллийн нэгдсэн сан	-	-	Үндэсний статистикийн хороо	Жендэрийн үндэсний хороо	-Олон улсын хөгжлийн түншлэгч, санхүүжүүлэгч байгууллагууд; -Үндэсний статистикийн хороо; -Судалгааны институтууд	
4.2.	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдлын суурь судалгаанд тусгагдсан үр дүнгийн асуудлаар нарийвчилсан судалгааны ажлуудыг эхлүүлэх	2021-2022	-Дундаж наслалтын хүйсийн зөрүүтэй байдалтай холбоотой гүнзгийрүүлэн хийсэн судалгааны тайлан	-	-	Жендэрийн үндэсний хороо			
4.3.	Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг хөгжүүлэх бодлогыг үндэсний түвшинд сурталчлах, хэрэгжилтийг хангасан аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах, сайн туршлагыг түгээх	2020 -2022	-Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг хэрэгжүүлсэн байгууллага, сайн туршлагын тоо	-	-	Жендэрийн үндэсний хороо		-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам; -Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо; -Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим;	

	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	2020-2021	-Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд согтууруулах ундааны савлагаа, өндөр градустай согтууруулах ундааны худалдаалах орчныг сайжруулах зохицуулалтыг нэмж тусгасан байна			-Аж ахуйн нэгж байгууллага -Хууль зүй, дотоод хэргийн яам; -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам; -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам; -Соёл урлагийн газар
4.4.	Эрэгтэйчүүдийн оролцоог дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, Төрийн бус байгууллагтай хамтран ажиллаж үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд таниулах, олон улсын байгууллагын дэмжлэгээр чадавхжуулах	2021-2022	-Эрэгтэйчүүдийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан; -Хөвгүүд, эрэгтэйчүүдийг хамруулсан үйл ажиллагааны тоо		Бүх шатны Засаг даргын Тамгын газар	Жендэрийн үндэсний хороо; -Олон улсын байгууллагууд
4.6.	Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2021	-Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлт	0	1000	Бүх шатны Засаг даргын Тамгын газар